



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2018.03.20 № 06/124.  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.3-д заасны дагуу Батширээт сумын ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Батширээт сумын ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Батширээт сумын ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Батширээт сумын ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР



**Аудитын код: ХЭА-2018/14/СТА-ТТЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: 0

Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112      Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390      Цахим хаяг:

Аудитор: Х.Еркегүл

Утас: 70562147, 99040705, Цахим хаяг: h erkegulkh@audit.gov.mn

**АГУУЛГА**

1	Аудитын тайлан .....	2
1.1	Оршил .....	2
1.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	2
1.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	3
1.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	3
1.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	4
1.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	4
1.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
1.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	5
1.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	6
1.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал .....	6
1.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал .....	6
1.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	7
1.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	7
1.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
1.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
1.12	Шилэн дансны мэдээлэл .....	8
1.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	8
1.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	8

## 1 Аудитын тайлан

### 1.1 Оршил

Батширээт сумын Төсвийн Ерөнхийлөн захирагч М.Болд-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Батширээт сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 6 төсвийн байгууллага, 4 орон нутгийн тусгай сан, сумын төрийн сан 1, орон нутгийн өмчид үйлдэрийн газар 4 зэрэг нийт 15 санхүүгийн тайлан нэгтгэсэн байна.

Ерөнхий боловсролын сургууль, ЭМТ-ийн санхүүгийн тайланд хувийн аудитын компани, сумын ЗДТГ, Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан байна.

Аудитаар дүгнэлт гаргасан байгууллагуудаас дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. ЗДТГ-ын санхүүгийн тайланд алдаа, зөрчил илрээгүй.
2. Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд төсвийн зарцуулалттай холбоотой 0.7 сая төгрөг,
3. ЕБС-ийн санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 0.1 сая төгрөг,
4. ЭМТ-ийн санхүүгийн тайланд анхан шатны баримтын бүрдүүлэлт, бүртгэл, тайлагналтай холбоотой 3.0 сая төгрөг,

Нийт 4.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг засаж залруулах зөвлөмж хүргүүлсэн байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг тухайн байгууллагын аудитын тайлангаас харах/

Батширээт сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын хүрээнд сумын ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, ЭЭС, Хавтгарын хөгжил, Сум тохижилт, Сум дундын ой ангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж дүгнэлт гаргав.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### 1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.3 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Батширээт сумын ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Батширээт сумын ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.15-наас 2017.03.20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.03.24-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ҮАГ-ын Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл хариуцаж хэрэгжүүлэв.

Батширээт сумын ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.03.15-нд төрийн аудитын байгууллагад 2017.03.05-ны өдрийн 33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

### **1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Батширээт сумын санхүү төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж гүйцэтгэлийг хангах нөөцийг оновчтой ашиглаж хариуцлагын тогтолцоог уялдуулах, төрийн сангийн шуурхай үйлчилгээг бий болгож төсөв санхүүгийн таатай орчин

“Батширээт сумын санхүү төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж гүйцэтгэлийг хангах нөөцийг оновчтой ашиглаж хариуцлагын тогтолцоог уялдуулах, төрийн сангийн шуурхай үйлчилгээг бий болгож төсөв санхүүгийн таатай орчин бүрдүүлэх замаар, санхүү эдийн засгийн үр ашигтай удирдлагаар хангахад оршино” гэж тодорхойлсон эрхэм зорилгын дор аймгийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Батширээт сумын ТЕЗ-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Батширээт сумын ТЕЗ-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

#### 1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Батширээт сумын ТЕЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлж мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Батширээт сумын ТЕЗ-ийн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Э тайлан” програм хангамж ашиглажээ.

#### 1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Батширээт сумын ТЕЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 3 асуудал эрсдэл өндөр, 2 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 9 буюу дунд эрсдэлтэй байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 3 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

**1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт орлогоос тооцоход улсын төсөвт төвлөрүүлдэг буюу байгууллагын үйл ажиллагаанд зарцуулдаггүй орлого нэмэгдэж тооцогдоно, нийт хөрөнгө болон цэвэр өмчийн дүн өндөр байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Батширээт сумын ТЭЗ-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2013.1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 20.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

Материаллаг байдлын түвшин болон нөхцөл байдал, шинж чанарын хувьд материаллаг байдал илрээгүй

**1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 3 чиглэлээр 3 эрсдэлтэй асуудалд горим, сорил хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үе шатанд нэг эрсдэлтэй асуудалд шинээр 1 горим сорил нэмж хэрэгжүүлэн, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй болно. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.



Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	(Сая төгрөгөөр)		
		Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	0	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	0	0.0	

### 1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, ГАРГАСАН ШИЙДЭЛ

Батширээт сумын ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг төлөвлөгөөны дагуу горим сорил гүйцэтгэхэд ТЭЗ-ийн хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллага, сангуудын санхүүгийн тайлангийн завсрын аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Соёлын төвд: Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 5 зөрчил,
2. ИТХ-д ИТХ-ын дэргэдэх малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчлан сэргийлэх сангийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 зөрчил,
3. ОНХС-нд анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой 60.0 сая төгрөгийн 1 зөрчил,
4. СХС-нд зээлийн хүүгийн орлогын бүртгэлтэй холбоотой 0.9 сая төгрөгийн 1 алдаа,
5. Сумын ЭЭС-д 19.6 сая төгрөгийн, сум тохижилтод 6.1 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 2 зөрчил илэрсэн байна.

Дээрхи завсрын аудитаар илэрсэн нийт 86.6 сая төгрөгийн адлаа, зөрчил илэрснээс 60,0 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 26.6 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгснийг жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

#### 1.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Батширээт сумын ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлөвлөгөөны дагуу горим сорил гүйцэтгэхэд төлбөрийн акт тогтоох алдаа, зөрчил илрээгүй болно.

**1.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал**

Батширээт сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлөвлөгөөны дагуу горим сорил гүйцэтгэхэд албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

**1.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Батширээт сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар санхилгын шийтгэл ногдуулах алдаа зөрчил илрээгүй болно.

**1.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Батширээт сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хууль хяналтын байгууллагад шилжүүлэх алдаа, зөрчил илрээгүй болно.

**1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал илрээгүй байна.

**1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Батширээт сумын ТЕЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1,263.8 сая төгрөгийн хөрөнгийн зардалд 120.6 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,461.3	1,383.6	94.7%	77.7
1.1	Урсгал зардал	1,263.8	1,222.0	96.7%	41.7
1.2	Хөрөнгийн зардал	120.6	120.6	0%	100
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	77.0	41.0	53.2%	53.2
2	Зардлыг сахуужуулэх эх үүсвэр	1,461.3	1321.0	90.4%	36.0
2.1	Улсын төсвөөс санхүүжих	892.6	871.0	97.6%	21.6
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0	0	0	0
2.3	Орон нутгийн төсвөөс санхүүжих	416.4	402.6	96.7%	13.8
2.4	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	114.1	7.3	6.4%	106.8

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 9.6 хувь буурсан нь улс болон орон нутгийн санхүүжилт 2.4 хувь, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 93.6 хувь буурсантай холбоотой байна.

#### 1.12 Шилэн дансны мэдээлэл

Батширээт сумын ТЕЗ-ийн “Шилэн дансны тухай” хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Санхүүгийн тайлангийн завсарын аудитаар:

1. Хуулийн 6.1.4: “Санхүүгийн тайлан /хагас жилийн/”-г хугацаа хоцроож мэдээлсэн
2. Хуулийн 6.1.5: “Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ”-ний талаар мэдээлэл байршуулаагүй.
3. Хуулийн 6.1.6: “Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар”-ыг хуулийн хугацаанд мэдээлсэн боловч төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтганы тайлбарыг бичиж оруулаагүй зэрэг зөрчил илэрснийг засаж залруулах зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллаж, жилийн эцсийн байдлаар “Шилэн дансны тухай” хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлсэн байна.

#### 1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх онд санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### 1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Батширээт сумын ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Батширээт сумын ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл байхгүй бөгөөд илэрсэн алдаа зөрчлийг энэ тайлангийн 1.8-д нэгтгэн тусгасан бөгөөд буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчил илрээгүй тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Х.ЕРКЕГҮЛ